

ӨГҮҮЛЭЛ

**БНСУ-ын эдийн засгийн хөгжлийн загвар, түүний хүрээнд
хэрэгжүүлсэн бодлого, үр дүн, сорилт****Дашдаваагийн Мягмар**^{ID}

Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэн,
Улаанбаатар, Монгол Улс
myagmar_d@mas.ac.mn

Хураангуй: БНСУ-ын Засгийн газар 1962 онд экспортын аж үйлдвэрийг хөгжлийн гарцаар сонгож, Япон Улсын жишигээр төрийн төлөвлөлт, хяналтын дор аж үйлдвэрийг дэмжиж эхэлсэн. Төрийн дэмжлэгийн дүнд аж үйлдвэрийн салбар эрчимтэй хөгжсөн ч тус улсын эдийн засаг гадаад орчны нөлөөнд мэдрэг болсон нь 1979 оны газрын тосны хоёр дахь хямралаар мэдэгдсэн тул эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах оролдлого хийсэн. Улмаар 1998 оны Зүүн Азийн санхүүгийн хямралд хүчтэй өртсөнөөр эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж, либералчлах арга хэмжээ авсан. Үүний үр дүнд тус улсын эдийн засаг дахь гадаад орчны нөлөө харьцангуй буурч, хараат бус байдал дээшилсэн. Гэвч сүүлийн жилүүдэд гадаад болон дотоод хүчин зүйлсийн нөлөөгөөр тус улсын эдийн засгийн гол зүтгүүр болсон аж үйлдвэрийн салбар өрсөлдөх чадвараа аажмаар алдаж, эдийн засгийн өсөлт саарч байна.

Түлхүүр үгс: БНСУ, эдийн засгийн өсөлт, хөгжлийн загвар, аж үйлдвэр.



Оршил

Аливаа улсын төрийн бодлого нь эдийн засгаа өсгөх замаар ард иргэдээ элбэг хангалуун, эрүүл, аюулгүй амьдруулах зорилго агуулдаг бөгөөд эдийн засгийн өсөлтийг тухайн улсын дотоодын нийт бүтээгдэхүүний өмнөх жилтэй харьцуулсан дүнгээр хэмждэг. Уг зорилгын хүрээнд эдийн засгийг системтэйгээр өсгөх арга буюу хөгжлийн загвараа сонгодог. Эдийн засгийг өсгөх зорилгоор зохион байгуулагдсан төрийн тогтолцоо, түүний зүгээс хэрэгжүүлдэг стратеги, бодлого, хөтөлбөрийг хөгжлийн загвар гэж болно. БНСУ-ын хувьд эдийн засгаа хөгжүүлэхэд хамгийн ойр бөгөөд бодитой жишээ нь Япон Улс байлаа. Дэлхийн хоёрдугаар дайнаас хойш Япон Улс газарзүйн ашигтай байршил, ажиллах хүчний арвин нөөц, капиталист системийн орнуудын дэмжлэгт тулгуурлан төрийн төлөвлөлт, хяналтын дор аж үйлдвэрийн салбарыг бодлогоор дэмжиж эдийн засгаа хөгжүүлсэн. Төрийн өндөр зохицуулалт бүхий хөгжлийн энэхүү арга барилыг АНУ-ын эрдэмтэн Чалмерс Жонсон Хөгжлийн улс (Developmental state) нэрээр анх тодорхойлсон байдаг¹. Азийн дөрвөн бар гэгдэж байсан Зүүн Азийн БНСУ, Тайвань, Сингапур, Хонконг улсууд энэхүү аргаар эдийн засгаа богино хугацаанд эрчимтэй өсгөсөн учир Зүүн Азийн хөгжлийн загвар гэж нэрлэх нь түгээмэл байдаг. Мөн төрийн манлайлал бүхий капитализм (state-led capitalism) гэх нь бий. БНСУ-ын Засгийн газар 1962

онд энэхүү загвараар эдийн засгаа хөгжүүлэхээр шийдвэрлэж, экспортын аж үйлдвэрийг төрийн бодлогоор дэмжих болсон юм. Гэвч уг загварыг баримталсан олон орон 1998 оны Азийн санхүүгийн хямралд өртөж эдийн засгийн хохирол амссан нь хөгжлийн өөр арга зам хайх шалтгаан болсон юм.

ОУВС, Дэлхийн банк болон АНУ-ын Сангийн яам хүйтэн дайн дуусахын өмнө буюу 1989 онд АНУ-ын Вашингтон хотноо зөвшилцөж санхүү, эдийн засгийн хямралд орсон хөгжиж буй орнуудад зээлийн санхүүжилт олгохын сацуу үе шаттай хөтөлбөрүүд хэрэгжүүлэх замаар эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийж хөгжлийн неолиберал загварт шилжүүлэхээр тохиролцсон байдаг². Өөрөөр хэлбэл хөгжиж буй орнуудын (социалист системд багтаж байсан болон бусад хөгжиж буй орнууд) эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж, бизнес, худалдааны орчныг чөлөөлж, зах зээлийг нээхээр тогтжээ.

БНСУ нь 1998 оны Азийн санхүүгийн хямралд өртөж, эдийн засаг нь дампуурлын ирмэгт ирсэн учир ОУВС-гаас их хэмжээний ам.долларын зээл авч, хямралаар гаргах хөтөлбөрт хамрагдсан. Дотоодын эсэргүүцэл их байсан ч улс орны эдийн засаг дампуурлын ирмэгт байсан учир аргагүй байдалд орж, ОУВС-гийн шаардлагын дагуу эдийн засагт бүтцийн томоохон өөрчлөлт хийсэн түүхтэй. Уг загварын нийтлэг тал нь худалдаа, хөрөнгө оруулалт, бизнесийн орчин

¹ Leftwich, Adrian, "Bringing politics back in: Towards a model of the developmental state", Journal of Development Studies, Volume 31, Issue 3 February 1995, pages 400-427

² 1989 оны Вашингтоны зөвшилцөл. (2020). Британника тайлбар толь. Cit 27/06/2025. Available at <https://www.britannica.com/money/Washington-consensus>

нээлттэй, эдийн засаг дахь төрийн оролцоо бага, төсвийн болон мөнгөний бодлогыг эдийн засгийг үр ашигтай удирдах гол арга хэрэгсэл болгон ашигладаг. Өөрөөр хэлбэл эдийн засаг дахь төрийн зохих ёсны зохицуулалттай

хөгжлийн загвар юм. Уг судалгаагаар БНСУ-ын Засгийн газар хөгжлийн дээрх хоёр загварын хүрээнд эдийн засагт ямар зохицуулалт хийж, ямар үр дүнд хүрсэнийг тодруулахыг зорьлоо.

1. 1962-1980 оны хооронд баримталсан Зүүн Азийн хөгжлийн загвар ба эдийн засгийн өсөлт

БНСУ-ын 1962 оноос 1980-аад он хүртэлх хугацааны хөгжлийн хэв маяг нь Зүүн Азийн хөгжлийн загвартай нийцдэг³. Улс орны санхүүгийн нөөцийг төрийн хяналт зохицуулалтын дор экспортын аж үйлдвэрийн салбарт чиглүүлж, богино хугацаанд эдийн засгийг хурдацтай өсгөдөг нь уг загварын онцлог юм. Засгийн газар нь татаас, хөнгөлөлттэй зээл, татварын хөнгөлөлт болон чөлөөлөлт зэрэг олон аргаар хувийн хэвшлийг дэмждэг. Колоничлолоос чөлөөлөгдөөд байсан Зүүн Азийн орнуудад далайд гарцтай, хүн ам ихтэй, ядуурал газар авсан, капиталист системтэй, барууны орнуудын нөлөө их зэрэг нийтлэг тал байв. Зүүн Азийн хөгжлийн загварыг баримталсан орнуудын эдийн засаг богино хугацаанд эрчимтэй тэлж, ажилгүйдэл, ядуурал буурсан. Гэвч төрийн хэт их оролцоо, санхүүгийн зах зээлийн уян хатан бус байдал, худалдааны хаалттай бодлого, авлига зэрэг асуудлаас үүдэн эдийн засгийн зах зээлийн жамаар хөгжих боломж хязгаарлагдсан нь хямралд хөтөлсөн. Энэхүү хөгжлийн загварыг “Хөдөлмөр,

капиталд суурилсан, иргэдийн эрх чөлөө, хэрэглээг хязгаарласан социалист маягийн хөгжил юм. Гайхамшиг гэх нь хэт гоёдсон нэр” гэх зэргээр П.Кругман зэрэг эрдэмтэд шүүмжилдэг⁴. БНСУ-ын хөгжлийн эхэн үе буюу 1960-аас 1970-аад оны сүүл хүртэл нийгмийн хөгжил хойш тавигдаж, хувь хүний болон хэвлэл мэдээллийн эрх чөлөө хязгаарлагдаж байсан. Нөгөөтэйгүүр АНУ-ын эрдэмтэн Ж.Стиглиц “Дэлхийн аль ч бүсэд Зүүн Азийн орнууд шиг цалинг эрчимтэй өсгөж, ядуурлаас богино хугацаанд нийтээрээ ангижирсан жишээ байхгүй” гэжээ⁵. БНСУ нь Зүүн Азийн хөгжлийн загварыг сонгох болсон дараах хэдэн шалтгаан байна. Үүнд:

1. Солонгосын дайны дараа буюу 1960-аад оны эхээр тул улсад төрийн авторитар дэглэм тогтсон нь эдийн засаг дахь төрийн өндөр хяналт, зохицуулалт бүхий хөгжлийн энэхүү загварыг баримтлах таатай нөхцөл болжээ.
2. БНСУ-д ажиллах хүчний хямд бөгөөд хангалттай их нөөц байсан. Тухайн үеийн

³ Don Moon, Jin-Young Chung. (2014). From “Developmental State Model” to “Neo-Liberal Model”: A Critical Review on the Debate over Korean Development Model. Cit 06/26/2025. Available at https://academic.naver.com/article.naver?doc_id=898897812

⁴ Joung Won Lee. (2005). The future challenges confronting the Korean economy: The national competitiveness strategies of the Participatory government. Cit 06/19/2025. Available at https://academic.naver.com/article.naver?doc_id=288535308

⁵ Мөн тэнд.

хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдлыг тус улсын судлаач Жөн Сөн Хүн “Бага цалин бүхий хангалттай олон тооны ажиллах хүч, хөдөлмөрийн маргааныг цэргийн хяналтын дор шийдвэрлэдэг, нийгмийн халамжийн систем байхгүй, онц нөлөө багатай цөөн тооны үйлдвэрчний эвсэл, холбоод байдаг”⁶ гэжээ.

3. БНСУ нь газарзүйн байршил, геополитикийн орчин, уур амьсгал, нөөц баялаг, соёл, зэрэг олон зүйлээр Япон Улстай ижил, төстэй байв. Мөн тус улс нь дэлхийн хоёрдугаар дайны өмнө Японы колони байснаас үүдэн худалдаа, эдийн засгийн маш ойр харилцаатай байсан нь уг хөгжлийн загварыг сонгох нэг үндэс болсон.

БНСУ-ын Засгийн газар хөгжлийн энэхүү загварын хүрээнд маш эрчимтэй, зоримог алхмуудыг эхлүүлэв. 1960-аад оны эхээр засгийн эрхийг цэргийн хүчээр авсан генерал Пак Жөн Хий-гийн засгийн газар 1962 онд Эдийн засгийн төлөвлөлтийн хороог байгуулж, экспортын аж үйлдвэрийг дэмжих бодлого баримталсан. Тэрээр төсөв, татвар, аж үйлдвэр, гадаад худалдаатай холбоотой бүх эрх мэдлийг Эдийн засгийн төлөвлөлтийн хороонд⁷ төвлөрүүлсэн. Банк, санхүү, худалдааны асуудал хариуцсан төрийн

захиргааны байгууллагууд уг хорооны шууд хяналтан дор ажиллаж эхэлсэн. Ингэснээр хөгжлийн бодлогоо нэг удирдлага дор харилцан уялдаатай, үр ашигтай төлөвлөн хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлжээ. Эдийн засгийн төлөвлөлтийн хорооны сар бүрийн экспортын хуралд ерөнхийлөгч Пак Жөн Хий төр барьсан 15 жилийн хугацаандаа гадаадад томилолтоор явсан таван удааг эс тооцвол сар бүр биечлэн оролцдог байв⁸. Цэргийн дарангуйлагч байсан хэдий ч ерөнхийлөгч Пак Жөн Хий нь улс орноо гадаадын зээл тусламжийн хараат байдлаас гаргаж, эдийн засгаа хөгжүүлэх чин сэтгэл өвөрлөсөн нэгэн байв. Түүний манлайлал, тууштай байдал, шийдвэр гаргах чадварыг зарим судлаачид тус улсын эдийн засгийн амжилтын томоохон хүчин зүйлд тооцдог.

Төлөвлөлтийн хороо нь эдийн засгийн хөгжлийг 5 жилээр төлөвлөж 1962-1992 он хүртэл 6 удаа хэрэгжүүлсэн. Эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөнд Хөнгөн үйлдвэрийг дэмжих хөтөлбөр (1960), Хүнд болон химийн аж үйлдвэрийг дэмжих хөтөлбөр (1970), экспортыг дэмжих зорилго бүхий Төвлөрсөн худалдаа эрхлэгч (1975) зэрэг томоохон хөтөлбөрүүдийг тусган хэрэгжүүлсэн. Тухайн үеийн давуу тал болох олон тооны хямд ажиллах хүчний нөөцөд тулгуурлан хөнгөн аж үйлдвэрийг санхүү, татвар, гадаад худалдааны

⁶ Sung Hoon-Jung. (2011). The Korean development strategy: Trajectories of Korean economic development, 1961- 2010. Cit 10/26/2024. Available at https://academic.naver.com/article.naver?doc_id=553218178

⁷ Эдийн засгийн төлөвлөлтийн хороо. (2024). БНСУ-ын мэдлэгийн цахим платформ. Cit 10/19/2024. Available at <https://terms.naver.com/entry.naver?docId=646847&cid=43124&categoryId=43124>

⁸ Жу Жэ Ху. (2023). Солонгосын эдийн засгийн хөгжил, энтерпренер сэтгэлгээ. Улаанбаатар хот, Монгол Улс: Мөнхийн үсэг. 84.

бодлогоор эрчимтэй дэмжсэн⁹. Аж үйлдвэрийн салбарт Үндэсний хөрөнгө оруулалтын сангаар дамжуулан дотоод санхүүгийн нөөцийг маш бага хүүтэйгээр олгож байсны сацуу үйлдвэрлэгчдийн гадаад эх үүсвэрээс авах өндөр дүнтэй зээлд Засгийн газар баталгаа гаргаж байв. Түүнээс гадна экспортын даатгал, зээлийн баталгаа, ашгийн татвараас чөлөөлөх, түүхий эдийн импортын татварыг буцаан олгох зэрэг аргаар уг салбарыг дэмжжээ. 1970-аад онд аж үйлдвэрийн салбарын дийлэнх хувийг хөнгөн үйлдвэр эзэлдэг байсан бол 2008 он гэхэд 83.5 хувийг хүнд болон химийн үйлдвэр,

16.5 хувийг хөнгөн үйлдвэр эзлэх болжээ¹⁰. Ийнхүү тус улсын эдийн засгийн гол зүтгүүр нь хүнд болон химийн аж үйлдвэр болсон байна. Аж үйлдвэрийн хөгжлөө дагаад экспортыг дэмжих, гадаад зах зээлийн орон зай гаргах шаардлага гарсан учир засгийн газар 1975 оноос Төвлөрсөн худалдаа эрхлэгч нэртэй хөтөлбөр хэрэгжүүлсэн. Олон улсын худалдааны орчин төдийлөн таатай бус байсны дээр өнөө цагт бүх аж ахуйн нэгжүүдэд нээлттэй байдаг худалдааны боломжууд тухайн цаг үеийн үйлдвэрлэгчдэд хаалттай байв. Учир нь БНСУ-ын Засгийн газар өсөлтийн шатандаа яваа дотоодын үйлдвэрлэлийг гадаад зах зээлийн өрсөлдөөнөөс хамгаалах үүднээс импортыг хязгаарлах (импортын

45 орчим хувийг төрөөс хянаж, хязгаарладаг байв¹¹) зэргээр гадаад худалдаанд харьцангуй хаалттай бодлого баримталсан. Мөн гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлаж байсан юм. Экспортыг нэмэгдүүлэх зорилгоор цөөн хэдэн томоохон корпорацад гадаад худалдаа, валютын гүйлгээтэй холбоотой олон тооны боломжийг төрөөс нээж өгсөн нь Төвлөрсөн худалдаа эрхлэгч хөтөлбөрийн онцлог юм. Уг хөтөлбөрийг эхлүүлсэн 1975 онд экспортын хэмжээ 5 тэрбум, гадаад худалдааны алдагдал 2 тэрбум ам.доллар байсан бол 1985 оны байдлаар экспортын хэмжээ 30 тэрбум болон 6 дахин өсөж, гадаад худалдааны алдагдал буурчээ¹². Тухайн үед арилжааны банкууд төрийн мэдэлд байсны дээр төрөөс валютын ханш болон зээлийн хүүгийн бодлогыг аж үйлдвэрийн салбарт хамгийн таатай нөхцөлөөр хэрэгжүүлж байв. Төрөөс экспортын аж үйлдвэрийг хэт дэмжсэний улмаас экспортын бус үйлдвэрлэл, эрүүл мэнд, нийгмийн халамж зэрэг бусад салбарын хөгжил хойш тавигдаж нийгмийн эсэргүүцэлтэй тулгарч байжээ. Тус улсын судлаач Жөн Сөн Хүн “Энэ үеийн БНСУ-ын аж үйлдвэрлэлийн салбарын онцлог нь массын үйлдвэрлэл – массын экспорт, өндөр бүтээмж – хямд ажиллах хүчний хослол байсан¹³” гэжээ.

⁹ Д.Мягмар. (2023). БНСУ-ын Засгийн газраас үндэсний үйлдвэрлэл, экспортоо дэмжиж буй хэлбэрүүд. Олон улс судлал. 63-83. №115.


¹⁰ Хүнд болон химийн аж үйлдвэр. (2024). БНСУ-ын мэдлэгийн цахим платформ. Cit 10/11/2024. Available at <https://terms.naver.com/entry.naver?docId=572695&cid=46631&categoryId=46631>

¹¹ Sung Hoon-Jung. (2011). The Korean development strategy: Trajectories of Korean economic development, 1961- 2010. Cit 10/26/2024. Available at https://academic.naver.com/article.naver?doc_id=553218178

¹² Гадаад худалдааны тоон мэдээ. (2023). БНСУ-ын Худалдааны хорооны цахим хуудас. Cit 10/29/2024. Available at <https://stat.kita.net/stat/kts/sum/SumImpExpTotalList.screen>

¹³ Sung Hoon-Jung. (2011). The Korean development strategy: Trajectories of Korean economic development, 1961- 2010. Cit 10/26/2024. Available at https://academic.naver.com/article.naver?doc_

Зураг 1. 1962-1980 оны гадаад худалдааны өсөлт (зуун мянган ам.доллар)



Эх сурвалж: 국가 수출입 총괄 : 국내통계 - K-stat 수출입 무역통계 (kita.net)
БНСУ-ын Худалдааны хорооны гадаад худалдааны тоон мэдээ

Зүүн Азийн хөгжлийн загварыг баримталж эхэлсэн 1962 онд тус улсын экспортын хэмжээ 5 сая, импортын хэмжээ 42 сая ам.доллар байсан бол 1979 онд экспортын хэмжээ 1.5 тэрбум, импортын хэмжээ 2 тэрбум ам.доллар болж өсжээ. Энэ 18 жилийн хугацаанд тус улсын гадаад худалдааны тэнцэл ямагт хасах дүнтэй явж ирсэн ч эдийн засгийн жилийн дундаж өсөлт 10 орчим хувьтай¹⁴ байв. БНХАУ болон Энэтхэг, Бразил зэрэг томоохон орнуудад орчин үеийн аж үйлдвэрлэл харьцангуй хожуу хөгжсөн нь БНСУ зэрэг Зүүн Азийн орнуудад богино хугацаанд эрчимтэй хөгжих боломж олгосон гэж зарим судлаачид үздэг. Мөн дэлхийн зах зээлд төмөр, зэс, хөнгөн цагаан зэрэг аж үйлдвэрийн гол түүхий эдийн эрэлт харьцангуй бага, үнэ хямд, эх үүсвэр элбэг байсан нь тус улсын эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлсэн юм.

Зүүн Азийн хөгжлийн загварын

хүрээнд төрийн хяналт, зохицуулалтын дор эдийн засгийн хөгжлийг төлөвлөн, худалдаа, хөрөнгө оруулалтын хаалттай бодлого баримталж, аж үйлдвэрийн салбарыг санхүү, татвар болон бусад хэлбэрээр эрчимтэй дэмжсэнээр эдийн засаг богино хугацаанд өндөр өсөлтийг үзүүлсэн. Гэвч төрөөс эдийн засагт хэт их оролцож, үйлдвэрлэгчдийг өргөн хүрээнд дэмжсэнээр тэдний зах зээлийн жамаар хөгжих боломж хумигдаж, өрсөлдөх чадвар муудан, гадаад орчны нөлөөнд мэдрэг болсон нь 1979 оны газрын тосны хямралаар мэдэгдсэн юм. Уг хямралаар дэлхийн зах зээлд нефтийн үнэ 2 дахин өсөж, шатахууны хомсдол нүүрлэжээ. Хямралын улмаас газрын тос, төмрийн хүдэр, нүүрс зэрэг түүхий эдийн импортоос өндөр хамаарал бүхий тус улсын хүнд болон химийн аж үйлдвэр зогсонги байдалд орж, ажилгүйдэл нэмэгдэж, инфляцийн түвшин 28,7 хувь хүртэл өсөж, эдийн засаг уналтад

id=553218178

¹⁴ БНСУ-ын эдийн засгийн өсөлтийн статистик. (2024). БНСУ-ын статистикийн албаны цахим хуудас. Cit 10/12/2024. <https://www.index.go.kr/unify/idx-info.do?idxCd=4201>

оров. Гадаад орчны нөлөөг бууруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх үүднээс тус улсын засгийн газар импортын түүхий эдийн эх үүсвэрийг төрөлжүүлж, эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж, либералчлах алхмууд хийсэн ч төрийн дэмжлэг авч сурсан томоохон корпорацуудын эсэргүүцэл, авлига, засгийн газрын туйлбаргүй байдал зэрэг асуудлаас үүдэн дорвитой үр дүнд хүрэхгүй

байсаар 1997 оны Зүүн Азийн санхүүгийн хямралтай золгосон¹⁵. Мөн төрийн дарангуйллыг эсэргүүцсэн ард түмний зүгээс нийгмийн шударга ёс, ардчилал, эрх чөлөөг шаардан бослого хөдөлгөөн өрнүүлсний дүнд 1987 оноос бүх нийтийн сонгуулиар ерөнхийлөгчийг сонгодог болсон нь улс төрийн ардчилсан тогтолцоо руу орох урьдач нөхцөл болсон.

2. 1998 оноос хойш баримталж буй хөгжлийн неолиберал загвар ба эдийн засгийн өсөлт

Эдийн засаг дахь төрийн оролцоо бага, хөрөнгийн урсгал чөлөөтэй, гадаад худалдаа нээлттэй, саадгүй байх нь уг загварын үндсэн шинж юм¹⁶. Уг загвар нь Адам Смитийн чөлөөт эдийн засгийн онолд суурилсан бөгөөд төрийн зүгээс төсвийн бодлого, мөнгөний бодлого, татварын бодлого зэргээр дамжуулан эдийн засгийг үр ашигтай зохион байгуулах боломжтой байдаг¹⁷. Мөн ядуурал, ялгаварлан гадуурхал, өвчин эмгэг, тэгш бус байдал зэрэг хүний эрхтэй холбоотой асуудалд төрийн оролцоо зайлшгүй байх ёстой гэж үздэг. Өнөөгийн дэлхийн дийлэнх ардчилсан улсууд хөгжлийн энэхүү загварыг баримталж байна. АНУ тэргүүтэй барууны хөгжингүй орнуудын удирддаг ОУВС нь эдийн засгийн хямралд өртсөн орнуудад санхүүжилт олгож, хямралаас гарахад нь туслахдаа энэхүү загварыг тулгаж, эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийж ирсэн. Өөрөөр хэлбэл хуучин социалист системд багтаж байсан

орнууд болон бусад хөгжиж буй орнуудын зах зээлийг нээж, өөрийн хөгжлийн загвартай ижилсүүлэх замаар нөлөөний хүрээгээ өргөжүүлж иржээ. Уг загварыг баримталсан орнуудад орлого тэгш бусаар хуваарилагдах асуудал түгээмэл байдаг. БНСУ нь дараах шалтгаанаар энэхүү хөгжлийн загварыг сонгох болсон. Үүнд:

1. Үйлдвэрлэгчдийг санхүү, татвар, худалдааны механизмаар хэт их дэмжсэн, нөгөөтэйгүүр тэднийг хамгаалах үүднээс худалдаа, хөрөнгө оруулалтын хаалттай бодлого баримталж байснаас үүдэн тэдний өрсөлдөх чадвар муудаж, гадаад орчны нөлөөнд мэдрэг болсон нь 1979 оны газрын тосны хямралаар мэдэгдсэн. Тиймээс үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхийн тулд дотоод зах зээлийг нээх, эдийн засаг дахь гадаад орчны нөлөөг бууруулах шаардлага байсан.

¹⁵ Kim Yun Hwan. (1994). The role of government in export expansion in the Republic of Korea: A revisit. 10-11. Cit 06/27/2025. Available at https://academic.naver.com/article.naver?doc_id=797210261

¹⁶ Неолиберализм. (2024). Британника тайлбар толь. Cit 11/12/2024. Available at <https://www.britannica.com/money/neoliberalism>

¹⁷ Мөн тэнд.

2. 1998 онд Азийн санхүүгийн хямралд өртсөн БНСУ-ын эдийн засаг дампуурлын ирмэгт ирсэн. АНУ, Япон зэрэг гол харилцагч орнуудаас зээл, тусламж хүссэн ч дорвитой амжилт олоогүй тул ОУВС-гаас ам.долларын зээл авахаар болж, тэдний мөрддөг журмын дагуу эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийх болсон.

1997 оны Азийн санхүүгийн хямрал нь тус улсын хөгжлийн загвараа өөрчлөх үйл явцыг нэг мөр болгожээ. Уг санхүүгийн хямрал нь дэлхийн эдийн засаг болон Зүүн Азийн хөгжлийн загвар зэрэгцэн орших боломжгүйг харуулсан эцсийн зогсоол байсан бөгөөд эдгээр улсууд төрийн манлайллаас илүүтэй зах зээлийн жам ёсны хөгжлийн загварыг дагахаас өөр гарцгүй болжээ¹⁸. Санхүүгийн зах зээлийг төрөөс хүчтэй хянаж, зохицуулж ирсэн явдал нь хямралд өртөх үндэс байсан бол дотоодын аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө болон өрийн харьцаа хэт өндөр түвшинд буюу 1997 оны байдлаар томоохон аж ахуй нэгжүүдийн өрийн дундаж хэмжээ нь өөрийн хөрөнгийн 500 хувийг давж байсан нь хямралын үндсэн шалтгаан болжээ¹⁹. Гадаад эх үүсвэрээс авсан зээлээ төлөх гэнэтийн шаардлага гарсан ч тухайн үед зээлийн төлбөрөө шууд төлөх боломжтой компани байгаагүй. ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд хөрөнгө болон өрийн дээд хязгаарыг 200 хувь болгон бууруулжээ. БНСУ-ын 30 том корпорацын 11- ийг

нь төлбөрийн чадваргүйн улмаас татан буулгаж, 9-ийг нь задлан хувааж бусад компанид нэгтгэсэн нь тус улсын эдийн засагт учирсан хамгийн том хохирол байв. Мөн бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөв хэмнэх, валютын ханш, хөрөнгийн урсгал болон гадаад худалдааг чөлөөлөх, санхүүгийн болон ажиллах хүчний зах зээлийн уян хатан байдлыг дээшлүүлэх зэрэг арга хэмжээ авсан. Тухайлбал хууль эрх зүйн хүрээнд өөрчлөлт хийж зах зээлийг нээж өгснөөр тус улсад орж ирэх гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ 1999 оноос огцом өссөн.

Азийн санхүүгийн хямралаас хойш хөдөлмөрийн зах зээл дэх төрийн оролцоог бууруулснаас үүдэн ажиллах хүчний зардал өссөн. Түүнээс гадна хөрөнгийн урсгалыг чөлөөлснөөр тус улсын корпорацууд БНХАУ болон Азийн бусад орнуудад шууд хөрөнгө оруулж үйлдвэрлэл эрхлэх явдал нэмэгдсэн нь экспортын өсөлтөд эергээр нөлөөлөв. 2002 онд тус улсаас БНХАУ-д хийх экспортын хэмжээ 18 тэрбум ам.доллар байсан бол 2010 онд 116 тэрбум болж өссөний дээр нийт экспортын дөрөвний нэг нь БНХАУ-д ноогдох болжээ²⁰. Ийнхүү БНХАУ нь тус улсын худалдаа, эдийн засгийн хамгийн том харилцагч болсон. Гадаад худалдааг чөлөөлөх бодлогын хүрээнд 1999 онд Чили улстай анхны чөлөөт худалдааны хэлэлцээрийг эхлүүлсэн бөгөөд өнөөгийн байдлаар 21 удаагийн хэлэлцээрээр дэлхийн 51 улстай чөлөөт худалдаа хийж байна. Мөн санхүүгийн

¹⁸ Don Moon, Jin-Young Chung. (2014). From “Developmental State Model” to “Neo-Liberal Model”: A Critical Review on the Debate over Korean Development Model, Journal of Asia-Pacific Studies Vol. 21. No. 2


¹⁹ 1997 оны санхүүгийн хямрал. (2024). БНСУ-ын мэдлэгийн цахим платформ. Cit 11/26/2024. Available at 1997 년 외환 위기 - 나무위키 (namu.wiki)

²⁰ Гадаад худалдааны тоон мэдээ. (2023). БНСУ-ын Худалдааны хорооны цахим хуудас. Cit 10/29/2024. Available at <https://stat.kita.net/stat/kts/ctr/CtrTotalImpExpDetailPopup.screen>

хяналт тавьдаг олон байгууллагыг нэгтгэх, санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг компаниудыг мэргэшүүлэх, аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн

зах зээлд оролцох боломжийг нээх зэргээр хөрөнгийн урсгалыг чөлөөлөх алхмуудыг хийжээ.

Зураг 2. 1998-2023 оны гадаад худалдааны өсөлт (зуун мянган ам.доллар)



Эх сурвалж: 국가 수출입 총괄 : 국내통계 - K-stat 수출입 무역통계 (kita.net)
БНСУ-ын Худалдааны хорооны гадаад худалдааны тоон мэдээ

Хөгжлийн неолиберал загвар баримтлах болсон 1998 оноос тус улсын эдийн засаг тогтворжиж, гадаад худалдааны тэнцэл ашигтай гарах болсон ч эдийн засгийн өсөлт жил ирэх тусам саарах (жилийн дундаж өсөлт 4 орчим хувь²¹) болжээ. 1979 оны газрын тосны хямрал болон 1998 оны Азийн санхүүгийн хямралаас авсан сургамжид үндэслэн банк санхүүгийн илүү найдвартай системийг бүрдүүлж, гадаад валютын нөөцийг зохих түвшинд хадгалж, түүхий

эдийн импортын эх үүсвэр болон эцсийн бүтээгдэхүүний экспортын зах зээлийг төрөлжүүлсний үр дүнд 2008 оны олон улсын валютын хямрал, Ковид-19 цар тахал болон Орос Украины дайны хямралыг харьцангуй эрсдэл багатай даван туулсан. Өөрөөр хэлбэл эдийн засаг дахь гадаад орчны нөлөөг бууруулж, аюулгүй байдлыг дээшлүүлснээр гадаад орчноос үүдэлтэй эрсдэлийг харьцангуй хохирол багатай даван туулах болжээ.

3. БНСУ-ын эдийн засагт тулгарч буй сорилт

Өмнөх үетэй харьцуулахад 1998 оны Азийн санхүүгийн хямралын дараагаас засгийн газрын эдийн засаг дахь оролцоо эрс багасчээ. Гэвч зарим судлаачид хөтөлбөрт

хамрагдсанаас хойш өмнөх үеийн эрчимтэй өсөлт саарч, орлогын тэгш бус хуваарилалт газар авсан гэх зэргээр шүүмжлэлтэй ханддаг²². Энэ нь бүтцийн өөрчлөлтийн дүнд цөөн хэдэн

²¹ Эдийн засгийн өсөлт. (2024). БНСУ-ын статистикийн албаны цахим хуудас. Cit 10/18/2024. Available at <https://www.index.go.kr/unify/idx-info.do?idxCd=4201>

²² Crotty, J., and K.K. Lee. (2002). "A Political-Economic Analysis of the Failure of Neo- Liberal

тооны корпорацид капиталын төвлөрөл үлэмж нэмэгдсэнтэй холбоотой. Эдийн засгийн өсөлт буурах болсон нэг томоохон шалтгаан нь тус улсын эмэгтэйчүүдийн төрөлт багасаж, нийт иргэдийн дундах өндөр настны тоо нэмэгдэх болсноор хүн амын өсөлт саарч, ажиллах хүчний дутагдалд орж байгаа явдал юм. Мөн нийт хүн ам дахь өндөр настны тоо нэмэгдсэнээр эрүүл мэнд, нийгмийн хамгааллын зардал тууштай өсөж байгаа нь эдийн засагт багагүй дарамт үзүүлэх болжээ. Зах зээл дэх корпорацуудын давамгайллаас үүдэлтэй орлогын тэгш бус хуваарилалт дорвитой буурахгүй байсан учир тус улсын засгийн газар ХХI зууны эхээс жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг бодлогоор дэмжиж байгаа. Гэвч ажиллах хүчний 80-аас дээш хувь нь харьяалагддаг жижиг дунд үйлдвэрийн салбар болон корпорацуудын ажилчдын цалин хангамж, өрсөлдөх чадвар өнөөг хүртэл эрс ялгаатай хэвээр байна. Тус улсын мэдлэг чадвартай, шилдэг ажилчид нь өндөр цалин, амьдралын баталгааг урьтал болгон корпорацуудад орж ажилладаг байна. Санхүү, технологи, капиталын өндөр потенциал бүхий корпорацууд нь уг давуу талаа ашиглан шилдэг хүний нөөцийг авч ажиллуулснаар өрсөлдөх чадварын хувьд жижиг дунд үйлдвэр эрхлэгчидтэй харьцуулшгүй давамгай болдог. Өрсөлдөөний давуу талыг нэгэнт олж авсан корпорацууд эдийн засгийн өгөөжийг илүү хүртэх нь орлогын тэгш бус хуваарилалтын үндэс болж байгаа аж. Орлогын тэгш бус

хуваарилалт нь нийгмийн тогтворгүй байдалд хүргэх эрсдэлтэйн дээр дотоод эдийн засаг тэлэхэд саад болдог тул тус улсын засгийн газар ажиллах хүчний дийлэнх хэсэг харьяалагддаг жижиг дунд үйлдвэрийн салбарийг тууштай дэмжиж байна. Нөгөөтээгүүр, сүүлийн жилүүдэд БНХАУ, Энэтхэг, Вьетнам зэрэг байгалийн баялаг ихтэй, ажиллах хүчний арвин нөөц бүхий улс орнуудын аж үйлдвэр, технологи хурдацтай хөгжиж байна. Энэ нь цаашид аж үйлдвэрт суурилсан эдийн засаг бүхий тус улсын өрсөлдөх чадварыг бууруулах эрсдэлтэй учир БНСУ-ын Засгийн газар нь ХХI зууны эхээс аж үйлдвэрийн технологийг сайжруулж бүтээмжийг дээшлүүлэх, мөн сансрын технологи, нано технологи, био технологи, цөмийн технологи, мэдээллийн технологи зэрэг өндөр технологи хөгжүүлэлтийг тууштай дэмжиж байна. Өөрөөр хэлбэл технологиор тэргүүлэх замаар ирээдүйн өрсөлдөөний давуу талыг олж авах, эдийн засгийн өсөлтөө хадгалахыг зорих болов.

БНСУ-ын аж үйлдвэрт суурилсан эдийн засгийн хөгжлийн оргил үе нэгэнт өнгөрсөн учир хөгжлийн загвараа сайжруулах цаг болсон гэж зарим судлаачид үздэг. Өөрөөр хэлбэл орлогын тэгш бус хуваарилалтыг бууруулж, дундаж давхаргыг өсгөх замаар дотоод эдийн засгийг тэлэх ёстой аж²³. Дотоод эдийн засаг тэлж байж эдийн засаг дахь гадаад орчны нөлөө улам бүр багасахын зэрэгцээ нийгэм, улс төрийн тогтворгүй байдал буурах юм. БНСУ-ын эдийн засгийн

Restructuring in Post-Crisis Korea.” Cambridge Journal of Economics 26 (5): 667– 678.

²³ Kang-Kook Lee. (2024). Korea’s economic growth and the growth model in the changing global economy. Cit 11/02/2024. Available at <https://www.tandfonline.com/doi/full/10.1080/2329194X.2024.2325981>

гадаад худалдааны хамаарал 88 хувьтай байгаа нь АНУ (22), Япон (47) зэрэг хөгжингүй орнуудтай харьцуулахад өндөр үзүүлэлт юм²⁴. Орлогын тэгш бус хуваарилалтыг бууруулах замаар дотоод эдийн засгийг тэлэхэд чиглэсэн бодлогыг тус улсын Засгийн газар өмнө нь хэрэгжүүлж байсан. Тухайлбал БНСУ-ын 19 дэх ерөнхийлөгч Мүн Жэ Ин нийгмийн өндөр орлоготой бүлэгт таатай хандаж ирсэн өмнөх үеийн Засгийн газруудаас (консерватив чиг баримжаа бүхий И Мен Бак болон Пак

Гын Хэ-гийн засгийн газар) ялгаатай эдийн засгийн бодлого хэрэгжүүлсэн. Орлогод суурилсан өсөлтийн (Income-led growth) бодлогоор дамжуулан эдийн засгийн өсөлтийг хадгалахын зэрэгцээ орлогын тэгш бус хуваарилалтыг багасгахыг зорьжээ. Гэвч олон сорилттой тулгарч дорвитой амжилт олоогүй. Ерөнхийлөгч И Жэ Мён дотоод эдийн засгийн хувьд Мүн Жэ Ин ерөнхийлөгчийнхтэй төстэй бодлого баримтлах төлөвтэй.

4. Хөгжлийн неолиберал загвар ба Монгол Улс болон БНСУ-ын онцлог

БНСУ төдийгүй Монгол Улс нь 1991 онд ОУВС-гаас ам.долларын зээл авч, хямралаас гаргах хөтөлбөрт хамрагдан, эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийсэн. БНСУ нь капиталист системтэй, аж үйлдвэрт суурилсан эдийн засагтай, гадаад худалдааны өргөн хүрээ бүхий сүлжээтэй байсан учир 1998 оны бүтцийн өөрчлөлтийг харьцангуй хохирол багатай даван туулжээ. Хөгжлийн суурь болсон аж үйлдвэрийн салбарын бүтээмж буураагүйн дээр эдийн засгийг либералчлах урьдчилсан бэлтгэлтэй байсан учир богино хугацаанд хямралаас гарсан. Бүтцийн өөрчлөлтийн дүнд эдийн засаг дахь гадаад орчны нөлөөг бууруулж, аюулгүй байдлыг өмнөх үеэс дээшлүүлсэн бөгөөд, улам бүр баталгаажуулахыг зорьж байна. Гэтэл эдийн засгийн төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцоо бүхий Монгол Улс урьдчилсан бэлтгэлгүй, гэнэтийн байдлаар өмч хувьчлал явуулж, гадаад

худалдааг тарифын зохицуулалтгүйгээр олон улсад нээснээр хөнгөн аж үйлдвэрийн салбар унаж, худалдааны хараат байдалд орсон түүхтэй. Улмаар Монгол Улсын эдийн засаг үндсэндээ уул уурхайд түшиглэх болсон. Эдүгээ нийт экспортын 90-ээс дээш хувийг уул уурхайн түүхий эд эзлэхийн зэрэгцээ БНХАУ-аас худалдааны хэт өндөр хараат байдалд орсон нь аюулгүй байдалд эрсдэл дагуулах болжээ.

Өнөөгийн БНСУ-ын Засгийн газар нь хөгжлийн неолиберал загварын хүрээнд Монгол Улсын адил эдийн засагт зохих ёсны зохицуулалт хийдэг. Тухайлбал Төлөвлөлт, сангийн яам нь эдийн засгийн урт болон дунд хугацааны хөгжлийг төлөвлөн хэрэгжүүлж байна. Төсвийн хөрөнгө оруулалтаар дамжуулан нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлууд, тухайлбал дэд бүтэц, орон сууц, нийгмийн халамж, эрүүл мэнд зэрэг салбарт зохицуулалт хийдэг. Төв банк нь Төлөвлөлт, сангийн яамны макро

²⁴ Дэлхийн банкны статистик. (2025). Cit 06/20/2025. Available at <https://data.worldbank.org/indicator/NE.TRD.GNFS.ZS?locations=KR>

эдийн засгийн бодлоготой уялдуулан мөнгөний нийлүүлэлт, хүүгийн бодлогоор ханшийг удирдаж, дотоодын хэрэглээнд (эдийн засагт) нөлөөлөхийг оролддог. Санхүүгийн зохицуулах хороо нь Хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгийн зах зээлд хяналт, зохицуулалт хийдэг.

Эдийн засгийг удирдан зохицуулах арга барилийн хувьд хоёр улсад дээр дурдсан нийтлэг тал байдаг ч төрийн өмчийн хэмжээ, аж үйлдвэрлэлийн бүтэц, түүнийг дагасан аж үйлдвэр, худалдаа хариуцсан төрийн байгууллагын бүтэц, үүргийн хувьд асар их ялгаа байна. Монгол Улсын нийт экспортын дийлэнх хэсгийг Эрдэнэт, Таван толгой зэрэг төрийн өмчит уул уурхайн үйлдвэрүүдийн бүтээгдэхүүн эзэлж байгаа бол БНСУ-ын экспортын дийлэнх хэсгийг Хёндэ, Самсунг, ЭлЖи зэрэг хувийн хэвшлийн корпорацуудын нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн эзэлж байна. Монгол Улсын төрд уул уурхайн үйлдвэрлэл хариуцсан асар

том бүтэц байдаг бол БНСУ-д хувийн хэвшлийн үйлдвэрлэл, худалдааг дэмжихэд чиглэсэн асар том тогтолцоо ажилладаг²⁵. Тухайлбал аж үйлдвэр болон гадаад худалдааг дэмжих, хилийн чанадаас уул уурхайн түүхий эдийн эх үүсвэр бүрдүүлэх үүрэгтэй Үйлдвэр, худалдаа, нөөцийн яам нь 39 хэрэгжүүлэгч агентлаг, олон мянган ажилтантай асар том байгууллага. Үйлдвэр, худалдааг дэмжих үүрэгтэй 1960-аас 1970-аад онд үүсгэн байгуулагдсан агентлагуудын чиг үүрэг өнөөг хүртэл өөрчлөгдөөгүй байна. Уг яамны харьяа Худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжигч агентлаг, мөн Байгаль орчин, уул уурхайн корпорац манай улсад ажилладаг. Монгол Улсын төр хамгийн том үйлдвэрлэгч болсноос үүдэн төрийн бүтэц том, эдийн засгийн үр ашиг багатай, авлига их, хувийн хэвшлийн бизнесийн боломж бага байгаа нь хөгжлийн неолиберал загварын үндсэн шалгуурт нийцэхгүй байна.

Дүгнэлт

БНСУ нь 1962 оноос төрийн өндөр хяналт зохицуулалтын дор экспортын аж үйлдвэрийг дэмжиж эдийн засгаа өсгөдөг Зүүн Азийн хөгжлийн загварыг авч ашиглажээ. Хөгжлийн энэ үед засгийн газраас эдийн засгийн хөгжлийг таван жилээр төлөвлөн санхүү, татвар, гадаад худалдааны бодлогоор аж үйлдвэрийн салбарыг эрчимтэй дэмжин хүчирхэг экспортлогч улс болох суурийг тавьсан. Дотоод хүчин зүйл болох засгийн газрын манлайлал, ажиллах хүчний нөөц, гадаад хүчин зүйл болох худалдааны таатай орчин, АНУ, Япон

тэргүүтэй капиталист системийн орнуудын дэмжлэг тус улсын эдийн засгийн хөгжлийн эхэн үед гол түлхэц болсон. Уг загварын хүрээнд аж үйлдвэрийн салбар хөл дээрээ боссон ч төрийн хяналт зохицуулалт өндөр, худалдаа эдийн засгийн хаалттай бодлого баримталж байснаас үүдэн 1979 оны газрын тосны хямрал, 1998 оны Зүүн Азийн санхүүгийн хямралд нэрвэгдсэн нь хөгжлийн загвараа өөрчлөх үндэс болсон. Улмаар эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж, санхүү, хөрөнгө оруулалт, худалдааг чөлөөлөх замаар 20-р зууны сүүлээр

²⁵ Д.Мягмар. (2024). БНСУ-ын экспортыг дэмжих тогтолцоо, Монгол Улсад хэрэгжүүлж болохуйц туршлага. Олон улс судлал. № 117. 66-81.

бүтцийн томоохон өөрчлөлт хийснээр хөгжлийн неолиберал загвар луу шилжсэн юм. Үүний дүнд эдийн засаг дахь гадаад орчны нөлөө харьцангуй буурч, эрсдэл даах чадвар дээшилсэн нь 2008 оны валютын хямрал, ковид-19 цар тахал зэрэг хямралыг хохирол багатай даван туулах үндэс болжээ. 21 дүгээр зууны эхээс тус улс нийгэм, эдийн засгийн үзүүлэлтээр хөгжингүй орны жишигт хүрсэн. Гэвч тус улсын аж үйлдвэрийн салбарын өрсөлдөх чадвар буурч, экспортын зах зээлээ ажиллах хүч болон түүхий эдийн нөөцөөр баялаг БНХАУ, Энэтхэг зэрэг хөгжиж буй орнуудад аажмаар алдаж байгаагийн зэрэгцээ ажиллах хүчний хомсдол, орлогын тэгш бус хуваарилалт, нийгмийн халамжийг зардлын өсөлт зэрэг дотоод эрсдэл нэмэгдэж байгаа нь тус улсын эдийн засагт томоохон сорилт дагуулж байна. Тиймээс тус улсын Засгийн газар орчин үеийн өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтөө хадгалахыг зорьж байна. Хөгжлийн неолиберал загвар

баримтлах болсноор БНСУ-ын эдийн засгийн өсөлт бага зэрэг саарсан ч эдийн засаг дахь гадаад орчны нөлөө буурч, аюулгүй байдал өмнөх үеэс дээшилжээ. Монгол Улс хөгжлийн энэхүү загварыг баримталсан 30 гаруй жилийн хугацаанд байгалийн баялгийн өгөөжөөр эдийн засаг олон дахин тэлсэн. Гэвч уул уурхайгаас бусад аж үйлдвэрийн салбар дорвитой хөгжөөгүйн зэрэгцээ гадаад худалдааны хувьд БНХАУ-аас өндөр хараат байдалд орсноор эдийн засгийн аюулгүй байдал эрсдэлтэй нөхцөлд байсаар байна. Эндээс харахад Монгол Улсад өндөр бүтээмжтэй аж үйлдвэрийг дэмжиж, экспортын бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх, мөн экспортын зах зээлийг төрөлжүүлэх замаар худалдаа, эдийн засгийн хараат байдлыг багасгах шаардлагатай. Энэхүү шаардлагад нийцүүлэн, Монгол Улсын онцлогт тохирсон хөгжлийн загвар боловсруулах, мөн энэ чиглэлийн судалгааг гүнзгийрүүлэн хийх хэрэгтэй байна.

Ном зүй / References:

1. Leftwich, Adrian. (1995). Bringing politics back in: Towards a model of the developmental state, Journal of Development Studies, Volume 31, 400-427.
2. 1989 оны Вашингтоны зөвшилцөл. Британника тайлбар толь. <https://www.britannica.com/money/Washington-consensus>
3. Don Moon, Jin-Young Chung. (2014). From “Developmental State Model” to “Neo-Liberal Model”: A Critical Review on the Debate over Korean Development Model. https://academic.naver.com/article.naver?doc_id=898897812
4. Joungh Won Lee. (2005). The future challenges confronting the Korean economy: The national competitiveness strategies of the Participatory government. https://academic.naver.com/article.naver?doc_id=288535308
5. Эдийн засгийн төлөвлөлтийн хорооны тухай баримт
6. <https://terms.naver.com/entry.naver?docId=646847&cid=43124&categoryId=43124>
7. Sung Hoon-Jung. (2011). The Korean development strategy: Trajectories of Korean economic development. https://academic.naver.com/article.naver?doc_id=553218178
8. Жу Жэ Ху. (2023). Солонгосын эдийн засгийн хөгжил, энтэрпренер сэтгэлгээ. Улаанбаатар хот, Монгол Улс: Мөнхийн үсэг.
9. Д.Мягмар. (2023). БНСУ-ын Засгийн газраас үндэсний үйлдвэрлэл, экспортоо дэмжиж буй хэлбэрүүд. Олон улс судлал сэтгүүл, №115.
10. Хүнд болон химийн аж үйлдвэрлэлийн тухай баримт <https://terms.naver.com/entry.naver?docId=572695&cid=46631&categoryId=46631>
11. Гадаад худалдааны тоон мэдээ. <https://stat.kita.net/stat/kts/sum/SumImpExpTotalList.screen>
12. БНСУ-ын эдийн засгийн өсөлтийн статистик. <https://www.index.go.kr/unify/idx-info.do?idxCd=4201>
13. Yun Hwan Kim. (1994). The role of Government in export expansion in the ROK: A revisit. https://academic.naver.com/article.naver?doc_id=797210261
14. Неолиберализм. Британника тайлбар толь. <https://www.britannica.com/money/neoliberalism>
15. 1997 оны Азийн санхүүгийн хямралын тухай баримт 1997 년 외환 위기 - 나무위키 (namu.wiki)
16. Гадаад худалдааны тоон мэдээ. <https://stat.kita.net/stat/kts/ctr/CtrTotalImpExpDetailPopup.screen>
17. Crotty, J., and K.K. Lee. (2002). A Political-Economic Analysis of the Failure of Neo- Liberal Restructuring in Post-Crisis Korea. Cambridge Journal of Economics 26 (5): 667– 678.
18. Kang-Kook Lee. (2024). Korea’s economic growth and the growth model in the changing global economy. <https://www.tandfonline.com/doi/full/10.1080/2329194X.2024.2325981>
19. Дэлхийн банкны статистик. <https://data.worldbank.org/indicator/NE.TRD.GNFS.ZS?locations=KR>
20. Д.Мягмар. (2024). БНСУ-ын экспортыг дэмжих тогтолцоо, Монгол Улсад хэрэгжүүлж болохуйц туршлага. Олон улс судлал сэтгүүл. № 47.

South Korea's Economic Development Model: Implemented Policies, Achievements, and Challenges

Myagmar Dashdavaa

*Institute of International Studies, Mongolian Academy of Sciences,
Ulaanbaatar, Mongolia
myagmar_d@mas.ac.mn*

Abstract: *In 1962, the South Korean government adopted an export-oriented industrialization strategy, following the example of Japan by promoting industry under state planning and control. As a result of strong government support, the industrial sector developed rapidly. However, the economy became sensitive to external factors, as evidenced by the impact of the second oil crisis in 1979. This led to attempts to reduce government intervention in the economy. Following the 1998 East Asian financial crisis, South Korea implemented liberalization measures to further reduce state involvement in the economy. As a result, the economy became relatively less influenced by external conditions and achieved greater independence. Nevertheless, in recent years, due to both internal and external factors, the country's industrial sector—which has been the main engine of economic growth—has been gradually losing competitiveness, leading to a slowdown in economic growth.*

Key words: *South Korea, economic growth, growth model, industry*

<i>The date of submission:</i>	<i>2025.05.21</i>
<i>Completion of review:</i>	<i>2025.06.27</i>
<i>Final decision for acceptance:</i>	<i>2025.07.21</i>